

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

| | | | |
|---|---|---------------------|-----------|
| Ярилцлага өгөгчийн нэр | Загдын Лувсанжамц | Дугаар | L079 |
| Оршин суугаа аймаг | Хэнтий | Оршин суугаа сум | Батноров |
| Төрсөн газар | Батноров сум | Төрсөн он | 1921 |
| Ажил мэргэжил | өндөр настан | | |
| Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд | Дарь-Эхийн хийд ба Данбажунайндандарпандэлин | Сүм хийдийн дугаар | ХЭБВ 108 |
| Одоогийн сүм хийд | | Сүм хийдийн дугаар | |
| Ярилцлага авсан он сар өдөр | 2007 оны 7-р сарын 17 | Ярилцлага авсан хүн | Ж.Одгарьд |



Дарь-Эхийн хийд ба Данбажунайндандарпандэлин

-Батноров сумд байсан сүм хийдийн талаар судалж явна. Энэ тухай таны мэдэх, сонссон дуулсан зүйлийг асуух гэсэн юм.

1990 оноос хойш шинэ хийд байгуулагдсан.

Дарь эхийн хийд гэдэг бол 3 дугантай. Цогчин дуган, ламрин дуган, манбын дугантай. 100 гаруй лам нартай байсан. Би өөрөө шавилан сууж байсан. Хэдэн онд байгуулагдсаныг мэдэхгүй. Лав л 200, 300-аад жил гэж хальт дуулсан. Дээр үеийн хууччуулын хэлснээр гэгээн гэдгийн төрсний ойд нь юм уу, таалал төгссөний ойд нь зориулж байгуулсан гэж Дарь эхийн хийдийг байгуулсан гэж тэгж нэг чихээр орж байсан.

-Та хэдэн настай байхдаа шавилж сууж байсан бэ?

8 настай анх суусан. Хэлмэгдлийн үеэр хаагдсан.

-Хэдэн жил суусан бэ?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

8 наснаас эхлэн 14, 15 хүртлээ 7,8 жил суусан байж таарах нь уу дээ.

-Дарь эхийн хийдэд ямар ямар онцлог хурлууд болдог байсан юм бэ?

Дарь эхийн хийд нь Манба дацандаа Манлын ван, Дүлцэн хурдаг. Дарь эхийнхээ хийдэд бүх л хурлуудыг хурна даа. Зуны хурал, өвлийн хурал, хаврын ерөөл гээд.

-Өдөр тутмын хуралтай байсан уу?

Өдөр тутмын хуралтай байсан. Манба бас өдөр тутмын Шаржин гэдэг хуралтай байсан. Ламрин бас өдөр тутмын хуралтай, цаг цагийн хуралтай байсан. Маанийн бүтээлтэй байсан.

-Майдар эргэж хайлан хурдаг байсан уу?

Майдар эргэдэггүй ээ. Хайлан хурдаг байсан. Дарь эхийн хурал зуны хурал гээд 3 өдөр их хурал хурдаг байсан. Чогонууд их хурна. Найдан чого, Хажидын чого гээд. Намар цогчин, зулын хурал гээд өвөл хуучныхаа хурлыг хураад Цэдэрээ хураад Титэг дормоо өргөөд дараа нь 15 хоногийн ерөөлөө хурна даа. Айлтгалын Ганжуур хурна. Сүүлийн үед гурван жил болов уу, хэлмэгдэж яваад ирсэн өвгөн лам Жамбалдорж гээд Дарь эхийн хийдэд анх маанийн бүтээлтэй болгож өгөөд тэгээд 2, 3 жил болоод тарсан даа.

-Дарь эхийн хийдийн төвд нэр нь юу гэдэг байсан юм бэ?

Төвд нэр нь Дамбажунай Дандарпандилин хийд гэдэг байсан. Нэлээн хэдэн лам нар нь баригдаад явсан.

-Та мяндагтануудыг нь санаж байна уу?

Хамба цорж байсан. Санжаа ловон гэж миний багш байсан. Тэр мөн хамба ламаар сууж байсан.

-Ширээт лам, унзад, гэсгүй нар?

Унзад нь Очирын Лувсаншарав гэж мундаг унзад байсан. Наваанлуvsан гэж хоёр том унзад нь байсан.

-Ширээт лам нь?

Ширээт байхгүй.

-Цорж лам нь?

Цорж байхгүй. Хамбын дараагийн лам нар палбин Шарав, Цэдэвийн Пунцаг гэж байсан. Нэг зурхайч лам байсан. Хамгийн түрүүнд Дарь эхийн хийдээс баригдсан. Ах дүү нь энүүгээр бий.

-Зурхайч нь хэн гэдэг хүн байсан юм бэ?

Ааяагийн Бальдир зурхайч гэж хүн байсан.

-Өөр гэсгүй нар нь хэн хэн гэдэг хүн байсан бэ?

Гэсгүй нь Лэгцэгийн Данзан гэж байсан. Нас барсан. Лувсанжамц гэж байсан. Нас барсан. Жамсран, Чой гэж байгаад нас барсан. Миний мэдэх дөрвөн гэсгүй.

-Дуган тус бүр нь гэсгүйтэй байсан уу?

3 дуган тус тусдаа гэсгүйтэй, хамбатай. Манба дацан нь их хуралтай байсан юм. Дуган сүмийг анх байгуулж өгсөн хүний ах дүү нар энд бий. Тэр Манба дацанг.

-Хэн гэдэг хүн хэдэн онд байгуулсан юм бэ?

Нэг туслагч байгуулсан гэдэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Нэр нь хэн гэдэг байсан бэ?

Санахгүй байна. Тэрний хүү Жанцан аграгмба гэж байж байгаад хотод баригдаад явсан. Наваанжанцан аграмба гэж. Тэрийг бол би сайн мэдэж байна. Баригдаад явсныг нь.

-Хувилгаан тодорч байсан уу?

Өвгөн Заяат ламын хойд дүр гээд Богдоос сунтаг шүүлгээд 5 настай хүүхэд тодорч байсан.Өөрөө цаг цагийн хуралдаа нэг суудаг байсан. Тэгээд наян хэдэн онд нас барсан. Манайд нэг тийм тодорч гарсан хүн байсан юм даа. Харз, Цант энэ тэрийн талаар хэлэх юм байхгүй.

-Дарь эхийн хийдийн дуганыг юугаар барьсан бэ?

Анх эхлээд Цогчэн дуган гэдгийг туйпуу, хятад юугаар барьсан юм бэ, хужаа барьсан гэсэн. Тэр нь 15 настай Халхын Гэндэн гэдэг хүн өөрөөсөө настай хүнтэй энэ уулын завсар уул, тэрнээс хойно шүү дээ, шохойн чулуу аваачиж байгаад шатаагаад тэндээ тэр давхар сүм гэдэг барьсан гэсэн. Тэр нь удаандаа муудаад тэгээд хожим модон дуган болгож барьсан гэсэн. Тэрнээс хойш Манба дацан, Ламрин дуганаа барьсан.

-Цогчэн дуган нь хоёр давхар сүм байсан уу?

Аа тэр ганц ганц.

-Хийдийн гар зураг бий юу?

Байхгүй.

-Ямар шүтээнтэй байсан бэ?

Дарь эх. Яахав дээ, Арван Хангалаа хүрж байлгүй яахав. Гэхдээ гол шүтээн нь Дарь эх. Нэг жоохон дарь эх байсан гэдэг. Манай ах Ваанчиг гэдэг хурал таруут авч үлдсэн юм. Дуганын араар онгорхой байсан. Тэрүүгээр нь ороод авсан. Хадгалж байгаад 1954 оны намар хэдэн өвгөчүүл цуглаад Дарь эх хуруулсан. Тэгсэн матагдаад бурханаа хураалгаад өөрөө шоронд явсан юм. Тэр Дарь эх хийд байгуулагдахад байсан хамгийн анхны Дарь эх. Тэр жаахан.

Ламиран гэдэг нь Богд ламын гол шүтээнтэй.

-Ном бурхдаас өөр хүн авч үлдсэн юм байгаа болов уу?

Байхгүй. Шатаагаад дуусгасан. Дуганыг нь дуусгаад хаясан.Тэр үед байж л байсан. Арван хэдэн настай байсан болохоор айгаад ойртох манатай. Сүүлд нь дуганыг буулгаад тэгээд дууссан.

-Дарь эхийн хийдэд ном барладаг байсан уу?

Үгүй. Харин төвд эмнэлгийн эмч нар байсан.

-Монгол эмч нар байсан уу?

Тийм.

-Голцуу аль хийдтэй харилцаа холбоотой байсан бэ?

Голдуу наашаа харилцдаг байсан. Дунд бүрднийхээ хийдийн хурал номд очдог байсан. Ганжуур, том хуралд тийшээ очиж хурдаг байсан. Би ч тэнд хүрж байсан. Орохдоо бол тэнд орсон. Тэгээд сүүлдээ манай нагац ах хойд чигийн хүн болохоор намайг нааш нь хийд рүүгээ татаад авчихсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Төвд лам нар ирж байсан уу?

Үгүй. Тийм юм байгаагүй.

Төвдийн сүм хийдтэй харилцдаг байсан уу?

Би бага байсан болохоороо сайн санахгүй байна.

-Жасын тухай? Хэдэн жастай байсан бэ?

Жас бол миний мэдэхээр Манба жас, Их жас байсан. Ламрин жас байгаагүй шиг байдаг юм аа.

-Жасын мал хөрөнгийн тухай?

Их л олон хоньтой байсан. Эхлээд жасад татвар ноогдуулсан. Тэгэхлээр жас өнгөтэй өөдтөйгөө зараад жасаа цааш нь харуулаад. Тэгээд сүм хийдийн тухай, лам нарыг муулсан тухай монгол бичгээр гарсан ном энэ тэр гараад. Түүнийг гэсгүй монгол бичиг мэддэг хүнээр уншуулаад тэгээд байдаг байсан. Тэгээд лам нарт татвар ноогдуулаад байгаа малаа зарах, хувцас хунараа, байгаа аль л өнгөтэй өөдтөйгөө зараад эхэлсэн. Тэгсээр байгаад лам нарын идэвх жаахан сулраад ирсэн. Тэгээд хурал хаах гээд 15 хоногийн ерөөлөө хураад тэгээд гэсгүй босоод багана цохиж цагийн байдал ийм боллоо. Хурлаа түр хаая. Дараа Данригаа хурахын ерөөл тавъя, тэгээд хурал тарж байхыг би сайн мэдэж байна.

-Хэдэн онд хурал хаагдсан бэ?

Би 8 настай хуралд хураад 8 жил суугаад хурал хаасан гэхээр тодорхой байх. 1921 онд төрсөн хүн чинь. 1937 онд хаагдсан.

-Хурал хаагдсанаас хойш яасан бэ?

Хаагдаагүй байхад л зурхайч лам Лувсандорж хоёрыг барьсан даа.

-Дуган сүмийг хэзээ буулгасан бэ? Буулгаад яасан бэ?

Ламиран дуганыг Идэрмэг сум авсан. Намайг цэрэгт явахад хоёр дуганын ор байсан. Ирэхэд байхгүй болсон байсан. Манбын дацан гэж хачин сайхан дуган байсан.

-Дарь эхийн хийдийн тухай нэмж хэлэх зүйл байна уу?

Чухам л болов шүү. Майдар байгаагүй, цам байгаагүй. Бусад хурлууд нь хийд хийддээ тохирсон хурал байсан байх. Ламрин бол яахав. Богд лам шүтээнтэй. Ламрины их хурал гээд их айхтар хураад байх юм байхгүй. Тийм л байсан. Гэхдээ бол яахав, Ламрины Шаржин гээд хурж байсан. Гол нь байнгын цогчэнтэй. Манба бол яахав, зуны цагт Манлаа хурна.

-Та тэр үед аль дацандаа голлож хурж юу судалж байсан бэ?

Гол шүтээнд байсан. Ерөөсөө Цогчэн уншдаг. Сүүлд Манбад ороод. Манбын Жинхарын тиг татуулаад нэг жил хэр дүлцон гэдэг жинхараас нь нэг жил хэртэй хийлцэж байсан. Түүнээс айхтар хураагүй.

-Одоо Дарь эхийн хийдэд сууж байсан лам нараас үлдсэн хүн бий юу?

Аймаг дээр Гончиг гэж нэг хүн байдаг. Ядруу л дуулдсан. Үхсэн гэж л дуулдаагүй. Бусад нь бүгд нас барцгаасан. Энд би л байна. 100 гаран ламтай байсан газар. Би нэг 96 хүргээд зогсдог юм.

-Та лам нарынхаа нэрийг бичиж тэмдэглэсэн үү?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хийдийн дуганын хойно нэг жижиг суварга байгаа. Тэрэнд л бичиж хийсэн. Хойд хийдийнхээ суварганд нэг хийсэн. Хуулбар авч үлдээгүй. Цээжээрээ л хэлж байсан.

Дарь эхийн хийдийн тухай бичиж тэмдэглэсэн юм байна уу танд?

Байхгүй, байхгүй.

-Та өөрийн санаж байгаа нэрсээсээ хэлэхгүй юу?

Даяанч Ишгомбо гэж байсан. Ааяагийн Бальдир. Том улсаа л хэлье. Замгүй юм болно. Лонцол гээд овгийг нь мэдэхгүй байна. Пагмын Шарав гэж байсан. Санжаа Ловон гэж өвгөн лам байсан овгийг нь сайн мэдэхгүй байна. Тэр бас хамба лам нь байсан юм. Сэрээтэрийн Пэрэнлэй, Очирын Лувсаншарав гээд том унзад, бас нэг унзад Наваанлуvsан, Сэрээтэрийн Шарав гээд бага унзад байсан. Жижиг лам олонтой. Гончигийн Чүлтэм гэлэн гэж алдартай эмч. Жодвоогийн Лхүндэг гээд эмч байсан. Чогдон гэлэн гэж бас нэг эмч байсан. Мундаг гурван эмч байсан юм аа. Гэсгүйгүүд нь Дэлгэрийн Данзан гавж гэж байсан. Жамсран гэж нэг гэсгүй байсан. Цэдэнчоо гэж нэг хүн байсан. Чойдог гэлэн гэж нэг гэсгүй байсан. Миний хурал хурж байх үеийнх л юм шүү дээ. Урдах нь ямар байсныг мэдэх биш. Том лам нар нь ийм л байсан даа. Сул лам нараас Лувсангончиг, Сог, Цэндийн Зундуй, Гунгаагийн Чойнжуур гэж байлаа. Мундаг уншлагатай лам нар байсан.

-Дарь эхийн хийдийн гол дуган нь дундаа байсан уу?

Тийм.

-Зүүн талынх нь Ламрин баруун талынх нь Манба уу?

Тийм.

-Харзны хийд хэдэн дугантай байсан бэ?

Ёстой мэдэхгүй. Би очиж байгаагүй. Цамт, Харзыг ердөө мэдэхгүй. Зос ч яахав. Нэг жаахан дугантай, цөөхөн лам нартай нэг тийм хурал байсан гэсэн. Идгаачойнзодлин гэдэг нэртэй хурал байсан байх. Харзны хийдийг л мэдэх хүн тун ховор байна даа. Тэр чигийн настай хүн дуулсан барьсан юм юу байдаг юм бол доо?

-Харзны хийд ямар нэртэй байсан бэ?

Мэдэхгүй. Би дуулсан. Мартчаад байна.